

*Эрдэм шинжилгээний өгүүлэл*  
УДК 94 (510)  
DOI 10.18101/2949-1657-2024-1-66-76

## ИХ ЮАНЬ УЛСЫН ҮЕИЙН ШҮТЛЭГ БА ОРДНЫ ХӨГЖИМ, БҮЖГИЙН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН СУДАЛГАА

© Алтангэрэл Эрдэнэзүрх

докторант,

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Монгол Улс, Улаанбаатар, 8 Хороо, Бага тойруу-14, 14191

erdirh915@163.com

**Хураангуй.** Бид Юань гүрний үеийн өргөлийн хөгжим, бүжгийг судлах зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийсэн. Мөн монголчуудын шашин шүтлэг, сүсэг бишрэл, тахилгын хөгжим, бүжгийн харилцан хамаарлыг харьцуулан судалж, судалгааны ажлын зарим үр дүнг танилцуулж байна. Судалгааны ажлыг хийхийн тулд Юань гүрний бүс нутгийн өргөл, тахилгын зан үйл, уран сайхны болон хөгжим бүжиг зэргийг судалж, хөгжлийн асуудлыг хөндсөн. Бидний үзэж байгаагаар Юань гүрний бүс нутгийн өргөл, тахилгын зан үйл, онцлог, хөгжим, бүжгийн талаарх судалгаа нь Монголын хөгжим бүжгийн хөгжилд төдийгүй, бүжгийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой юм. Монголын түүхийн дагуу Юань гүрний үед ордны хөгжим, бүжиг хөгжсөн. Иймээс бидний судалгааны ажилд энэхүү хөгжлийн хурдад нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тусгасан болно. Манай судалгааны ажил Монголын төр, засгийн эхэн үеийн бөө мөргөлийн улс төр, шашны утга учрыг харуулсан судалгааны бүтээлүүдийг тусгаж, түүхэн баримтад тулгуурлан тэнгэрийн өргөл, тахилгын ёслолын онцлох ёслолыг дурдсан. Бүжгийн хөдөлгөөнийг тэнгэрийн тахилгын үеэр хийдэг бөө мөргөлийн зан үйлд оруулдаг байсан нь энэ үед урлагийн янз бүрийн төрлүүдийг салгаж чадаагүй боловч цогц ёслолын хэлбэрээр явагддаг байсан гэж үзэж болно. Иймээс хүмүүсийн итгэл үнэмшил нь эдгээр ёслолын дууны үг, хөгжим, үйл ажиллагаа, үзүүлбэр, дүр төрх, дүрд шүтэх нарийн төвөгтэй байсан.

**Түлхүүр үг:** Юань гүрэн, ордны бүжиг, бөө мөргөл, тахилга, ордын хөгжим, монголын хаад.

### Ишлэл

*Алтангэрэл Эрдэнэзүрх.* Их Юань улсын үеийн шүтлэг ба ордны хөгжим, бүжгийн харилцан хамаарлын судалгаа // Восточный вектор: история, общество, государство. 2023; 1: X. 66–76.

**Удиртгал.** Бид судалгааны өгүүлэлээ Монголын Юань гүрний үеийн тахилгын хөгжим бүжгийн уламжлалын асуудлыг судлан шинжлэх зорилгоор бичсэн бөгөөд монголчуудын шүтлэг ба хөгжим бүжгийн харилцан хамаарлын асуудлыг харьцуулан судлахын зэрэгцээ судалгааны зарим үр дүнг танилцуулахыг хичээлээ. Уг судалгааг хийхдээ Юань гүрний үеийн тайлга тахилга, хөгжим болоод бүжгийн онцлогийн асуудлыг авч үзлээ.

Монголын Юань гүрний үеийн тахилгын хөгжим бүжгийн уламжлалын асуудлыг судлах нь Монголын урлаг, соёлын түүхийн талаарх судалгаанд ихээхэн ач холбогдолтой хэмээн үзсэн болно.

Монгол төрийн бүжиг төр улс бий болсон үеэс төлөвшсөн нь тодорхой боловч түүний уг сурвалж нь овгийн байгууллын үе, ялангуяа бөө мөргөл, тэнгэр

тайх естой холбоотой. Тухайлбал, Их Монгол улсын үед бөө мөргөл төрийн шашны шинжтэй байж тэнгэр тайх, тахих еслолыг сүр хүчин төгөлдөр үйлддэг байсныг түүхэн сурвалжуудаас үндэс болгон судалсан болно. Чингэхдээ тэнгэр тайх еслолын үед үйлддэг байсан бөөгийн зан үйлийн хөдөлгөөнд бүжгийн үүсгэл байсан гэж үзэх үндэслэлтэй хэмээн үзэж болохоор байна. Учир нь эртний үед урлагийн олон төрлүүд зааглан салбарлаагүй, нийлэг цогц байдалтай байсан бөгөөд үгийн болон хөг аялгуу, үйл хөдлөл, дүрс хэлбэрийн ид шидэнд итгэх шүтлэг нэгдмэл байсан билээ.

Монголчуудын төр есны уламжлалын талаар Хүннү гүрний үеэс сурвалж бичигт тэмдэглэгджээ. Анхны төр улс үүссэн үед нүүдэлчдийн онцлог бүхий төрийн еслолтой байжээ. Энэ төр еслолын бүрэлдэхүүн хэсэг нь төрийн бүжиг юм. Энэ нь яруу сайхнаар цэнгүүлэх зориулалтын зэрэгцээ зөн бэлгэдлийн, хүндэтгэлийн учир утга бүхий байсан байна.

Мөн төрийн буюу ордны бүжиг нь их найрал хөгжимтэй хоршин нэгэн цогцолбор болж байв. Хүннүгийн үед ордны бүжиг байсан тухай түүхэн сурвалжид дурдсан баримт буй. Хятан улсын хаадын өргөөнд олон бүжигчид төрийн еслолын бүжиг хийдэг байсан тухай түүхэн сурвалжид тэмдэглэгджээ.

XIII–XIV зууны үеийн Монголын хаан ширээнд суух еслол, дайллага хүлээн авалтын болон хаад хатдын зураг хадгалагдан үлдсэнээс харахад хувцас өмсгөлийн загвар нь өнөөг хүртэл уламжлагдсаар иржээ. Ийнхүү төрийн бүжиг нь эртний улсуудын үед улс бүрт түүхэн үеийн онцлогийг хадгалж уламжлан залгамжлагдсаар Их Монгол Улсын үед төгөлдөр их чуулбар болжээ. Эзэн богд Чингис хаан соел иргэншил бүхэнд тэгш ханддаг зарчимтай байснаар Их Монгол Улсын төрийн ордны бүжиг нь нүүдэлчин, суурин иргэдийн урлагийн хослол болсон байна. Их Монгол Улсын ордны бүжиг нь ийнхүү монгол язгуур уламжлалаа хадгалахын зэрэгцээ түүний бүрэлдэхүүнд багтаж байсан дорно, өрнийн улс үндэстнүүдийн бүжгээр улам баяжиж цогцолбор шинжтэй болсон тухай өөрийн гаргалгаа дүгнэлтийг энэхүү судалгааны ажилдаа дэвшүүлсэн болно.

Хубилай хааны ордонд ихэс дээдэс, хаад хүртэл өөрсдөө бүжиглэдэг байсан ажээ. Монголын их еслолоор биелгээ бүжиг бүжиглэсэн гэж их Юань гүрний түүхийн орчуулга бичгийн гэрчлэлийн нөхвөрт тэмдэглэсэн байдаг байна. Эдгээрээс үзэхэд ардын бүжгийн эх үүсвэр эртнээс уламжлагдан ихэс доодосгүй бүжин цэнгэгцээдэг байсан бололтой. Мөн дуулалт бүжиг, хундаганы бүжиг гэх мэтээр олон төрлийн бүжгийг бүждэг байжээ. Энэ бүхэн нь монгол төрийн бүжиг ордны бүжгийн шинжээр баяжин олон төрөл хэлбэртэй болсныг харуулсан нотолгоо хэмээн үзэж байна.

Тиймээс Их Юань гүрний үеийн тахилгын хөгжим бүжгийн уламжлалын асуудлыг тайлга тахилга ба бүжиг, хөгжмийн зэмсэгийн онцлог, үүтгэл, ялгамжаатай байдлыг тодруулах зорилгоор судлахын зэрэгцээ бүжиг хөгжмийн зэмсэгийн төрөл зүйл, хөгжлийн түүхийг тайлбарлах шаардлага зүй есоор тулгарч байна.

### **1. Монголчуудын шүтлэг: тайлга тахилга**

Их Юань гүрний ордны тахилгын хөгжим бүжгийн тухай судлахад юуны урьд Монголчуудын шүтлэг ба Монголчуудын хөгжим бүжгийн түүхээс эхлэн судлах хэрэгтэй.

Монгол газар эртнээс байсан шүтээн болбоос тэнгэр лусыг хамгийн их эзэн болгож шүтэх явдал болно. Бас газар усны эзэн хэмээн нутаг нутгийн зан аалиар

шүтэж баймой. Бас орон нутгийн эзэд хэмээн айл бүрийн орны зан аалиар шүтэж баймой. Их эрт цаг эмгэн цагаан өвгөн буурал хэмээх хоёр ижлийг шүтэж баймой. Бас баатар нэртний гарсан орныг шүтэж баймой. Эдгээрийг шүтэхээс гадна бурхны сургаал Монгол оронд дэлгэрснээс одоо бурхны нэр хөргийг бүтээж, сүм суварга байгуулж, шүтээн болбоос гурван цагийн бурхан Шагжмуни Майдар, Аюуш гурван бурханыг голдуулж шүтээн болговой. Бас Хорин нэгэн дарь эх Арьяабал, цагаан ногоон Дарь эх, Оточ, Манзушир, Махгала охин тэнгэр, эрлэгийн хаан Долоон догшин эдгээр бурхан шүтээнээс Чин улсад хүрч ирээд Гуан ло еэ-ийг шүтээнээ болгож шүтэж баймой. Сүмээс гадна өрх гэрийн хүү нар ч сүсэгтний гэрт сүм мэт олон бурхадын зураг хөрөг бүтээж тахиж шүтэж явмой<sup>1</sup>. Жишээлбэл: Домог зүйн талаас авч үзвэл учир ухаан нь их амархан олдоно.

Нүүдэлчин монголчуудын дайны хөлд нэрвэгдсэний улмаас ард иргэд ядуурлын байдалд орж, алтан урагийнхан хаан суудал булаалдан өөр зуураа тэмцэлдэх болов. Энэ их өрсөлдөөнд Эзэн Богд Чингис хааны хөвгүүн Тулуйн дөрөвдүгээр хүү Хубилай ялалт байгуулж, 1260 оны 5 дугаар сард Хубилай “Жүн Түн” хэмээх оны цолыг, 1271 онд “Их Юань” хэмээх оны цолыг авч, Их Юань гүрнийг дэлхийд тунхагласан байна. Хубилай хаан төр бататгах арга бодлогоо боловсруулж, жишээлбэл: Алтан улс Сүн улсын хэрэглэж байсан төрийн бодлого, засаг захиргааны бүтцийг хэвээр нь үлдээж, харин Хятадын Күнзийн сургаалд ноёд түшмэдийг дээгүүр албан тушаалд оруулах эрхийг нь бүрмөсөн хоригложээ<sup>2</sup>.

### **2. Шүтлэг ба хөгжим бүжгийн далд нэгэн холбоос**

Шүтлэг тайллага тахилга, хөгжим бүжиг гэж юуг ойлгож болох вэ? Шүтэх гэдэг бол ямар нэгэн бурхан сахиусны ба хүн хийгээд онол үзэл санааг өчүүхэн ч эргэлзэлгүйгээр итгэн бишрэхийг хэлдэг хэмээн монгол тайлбар тольд тайлбарлажээ. Шүтэн бишрэх сэтгэлийн удирдлага дор шүтлэгээр хандуулсан олон зан үйл буй болдог. Шүтлэгийн онц нэгэн илэрхийлэл нь тайллага, тахилгын зан үйл болно. Тайллага тахилгын еслолоор тахилгын талбайг хөгжөөх, олны анхаарлыг татан авчрах, хамтын нэгэн үйлээр оролцогч олны чин сэтгэлийн хүсэлтийг илэрхийлэх, олны сэтгэлийн халуун илчээр шүтээн онгоныг баясгах зорилгоор хамтын хөгжмийг аялан хамтын бүжгийг бүждэг байна. Мөн тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалж ганц хоёр хүмүүн үйл үйлдэхээ илэрхийлж байдаг. Ая хөгжим гэдэг бол үндэстэн ястны түүхнээ урт удаан жилийн соелын уялдаа холбоотой. Нүүдэлчдийн соелын түүхээс үзвэл ая өргөж, дуу барих нь машид хүндэтгэлийн нэгэн зүйл болно. Манай өдөр тутмын амьдралд хэрэглэж байгаа хөгжмийн нэр томъёо бол аялга хөг, айзам цохилго гаргах зэмсгийг заадаг, мөн ч урлагийн мэргэжилд хөгжмийн зэмсэг буюу хөгжимдүүр хэмээх тусгайлсан нэрээр нэрлэдэг юм.

### **3. Их Юань гүрний ордны бүжгийн уламжлалт соел**

Эртний монголчуудын “дэвсэх” гэж хэлдэг нь ихэвчлэн хөлийн хөдлөлд тусгагдаж байдаг нь тодорхой. Хурим найр, тахил тайлгын еслолд эзэд сахиусыг баясгахаар гартаа тахилын идээ өргөх, мөн гар гараасаа холбогддог учир хөл нь

<sup>1</sup> С. Дулам. Монгол домог зүйн дүр. Өвөрмонголын соелын хэвлэлийн хороо. Хайлаар, 1998. Х.1.

<sup>2</sup> Дулам С. Дорно дахины уран зохиолын үүд. Улаанбаатар, 2004. Х. 161.

чөлөөтэй байдаг. Үүнээс үзвэл бүжиг бол овог аймгийн тахил тайлгын зан үйл төгссөний дараа нийтгэч шинжтэй зугаа цэнгэл буюу наадмын шатанд шилжсэн үеийн хөгжмийн аялгуун дор нийлэн наадахуйг хэлж байна.

Судлаачдын тэмдэглэснээр эрт үед хаан эзэн суух, дайн байлдаанд орох, ялалтаа тэмдэглэх, гай барцадыг зайлуулах зэргийг тэнгэрт даатган бөө бөөлүүлж, бүжиглүүлдэг байжээ. Бөөгийн бүжиглэл нь утга санаагаа онгон сахиус, сүнс сүлд, зэрэг оюун санааны ертөнцтэйгээ харьцах зан үйлээр дамжуулан илэрхийлдэг бол цамын бүжиглэл буддын шашны гүн ухааны агуулгатай багт бүжгийн төрөл бөгөөд агуулга, утга санаа, орчин, хугацаа, найруулга, хөдөлгөөний зохиомж гээд бүжгэн жүжгийг бүтээх гол хүчин зүйлс бүгд багтсан байдгаар бүжгэн жүжгийн төрөл ч гэж бүжгийн мэргэжилтнүүд үздэг.

Монголчуудын төрийн бүжиг нь эхний шатандаа нүүдэлчний аж төрөх есонд зохицсон, бөө мөргөлийн зан үйл бөөлөх үйл хөдөлгөөнтэй холбоотой өвөрмөц онцлогтой байсныг тэмдэглэх хэрэгтэй. Монголчуудын төр есны уламжлал нь Хүннү гүрний үеэс сурвалж бичигт тэмдэглэгджээ. Анхны төр улс үүссэн үед нүүдэлчдийн онцлог бүхий төрийн еслолтой байжээ. Энэ төр еслолын бүрэлдэхүүн хэсэг нь төрийн бүжиг юм. Энэ нь яруу сайхнаар цэнгүүлэх зориулалтын зэрэгцээ зөн билэгдлийн, хүндэтгэлийн учир утга бүхий байсан байна.

Монголын уламжлалт бүжгийн хэлбэрийн нэг бол ордны бүжиг юм. Монголын ордны бүжгийг XII-XIII зууны үеэс эхэлсэн гэж зарим судлаачид үздэг бол нэн эртнээс монголчуудын орд харшид бүжиг наадуулж байсан тухай сурвалж мэдээ цөөнгүй байна.

XIII зууны үед монгол газраар явсан жуулчин Марко Пологийн тэмдэглэл “Их хаадын орд” гэдэг зохиолын “Өдий төдий ятгач нар хөгжмөө цохих зэргээр хааны уух тасам хэзээ дуустал нь хөгжмөө дуугаргана. ... зоог дууссаны дараа ширээ сэлтээ зайлуулмагц хөгжимчин, дуучин, алиачин, илбэчин, хотгоочин, /баг өмссөн наадагч/ тэргүүтэн орж ирээд, их хааны өмнө тус тусын эрдэм чадал, уран сайхнаа үзүүлж, их, хаан зочдыг баясуулна”<sup>1</sup> хэмээн гадаадын жуулчид хааны ордоны бүжиг, хөгжмийн тухай тэмдэглэн үлдээжээ. Түүнчлэн Марко Пологийн тэмдэглэлд “мангас, махчин зэрэг хүний нүүр царай, амьтны толгойг дуурайлган хийсэн багийг өмсөөд бүжиглэдэг хүнийг “хотгоочин”<sup>2</sup> гэж нэрлэж байлаа гэсэн нь ихээхэн сонирхол татна. Энэ “хотгоочин” нь дуулах, бүжиглэх эрдэм чадал төгс байсны зэрэгцээ өнөө цагийн жүжигчин, бүжиглэх чадвар хосолсон тайзны урлагийн хөгжлийн эх үндсийг тавьсан болов уу хэмээн үзэж болох мэт.

Ялангуяа Юань гүрний хааны ордон Дайду хотноо шилжсэнтэй холбогдон монголын бүжгийн язгуур уламжлалыг олон үндэсний бүжгээр баяжуулсны дотор хятад бүжгийн нөлөө их байсан бололтой. Их Юань гүрний үед төрийн еслол хүндэтгэлийн бүжиг нь төгөлдөр шинжийг олсон бөгөөд дуу, хөгжим, бүжиг хавсарсан бүрэлдэхүүнээр хүндэтгэл еслолын бүжгүүдийг хийдэг байжээ.

Их Юань улсын судар бичгийн 70 дугаарт өгүүлснээс үзвэл “Дээдсийн сүмийн их танхимд янз бүрийн хөгжмийн багштай 312 хөгжимчин ордны найрал хөгжмийн бүрдэл болж 312 эрэгтэй, эмэгтэй бүжигчид хөгжмийн аянд

---

<sup>1</sup> Хэрлэн Г. Монгол ардын хөгжмийн зэмсгийн түүхээс. Улаанбаатар, 2009. Х. 17.

<sup>2</sup> Хэрлэн Г. Монгол ардын хөгжмийн зэмсгийн түүхээс. Улаанбаатар, 2009. Х. 18.

бүжиглэдэг, тэдгээр бүжигчид алтан хатгамал магнаг хувцастай, өмссөн малгай нь янз бүр, зарим хөгжимчин далавчтай малгайтай, зарим нь янз бүрийн сайхан алчууртай, түүнийгээ сувд, эрдэнийн чулуугаар чимсэн, үзүүрийг нь гое сайхнаар зангидсан байдаг байжээ. Бүжигчид бүжиглэж дуусаад хоёр талын шатлан тавьсан өндөрлөг дээр үелэн, эгнэн зогсч, дараагийн гарах бүжигчдэд зай тавина.

Эмэгтэй бүжигчид нь хошуурсан урт ханцуйтай, гар буюу цээжин бие нэвт гэрэлтсэн алтан утсаар сүлжсэн сиймхий торгон саа хувцсаа өмсөцгөөн гартаа мандарваа цэцгийн баглаа болон эрхи барин тэнгэрийн дагинасыг дүрслэн бүжиглэсний дараа эрэгтэйчүүд нь нөгөө талын шаталсан өндөрлөгөөс бүжгийн удирдагчийн дохиогоор Хангарьдын жигүүртэй тогосын гялалзсан өд, өнгөт шилэн эрдэнийн чимэгт хувцастай, далавчаа дэвэн хангарьдын бүжиг хийгээд байрандаа очиж зогсоно. Бүжиг удирдагч чимэгт таягаа дохиход бүх бүжигчид хамтран ордны бүжгийг бүжин наадна” хэмээн дэлгэрэнгүй өгүүлжээ. Тэр үеийн хөгжмийн зэмсэг нь бадралт баг бишгүүр, бүдүүн нарийн, урт богино олон лимбэ мэтийг баглан хөөрөгдөн дуугаргадаг байжээ. Тухайн үед ордны олон тооны бүжиг байсныг ч түүхийн сурвалжууд тодорхой өгүүлдэг.

Монголын их еслолоор биелэгээ бүжиг бүжиглэсэн гэж Их Юань улсын түүхийн орчуулга бичгийн гэрчлэлийн нөхвөрт тэмдэглэсэн байдаг байна. Эдгээрээс үзэхэд ардын бүжгийн эх үүсвэр эртнээс уламжлагдан дээдэс, доодосгүй бүжин цэнгэцгээдэг байсан бололтой. Мөн дуулалт бүжиг, хундаганы бүжиг гэх мэтээр олон төрлийн бүжгийг бүждэг байжээ. Энэ бүхэн нь монгол төрийн бүжиг ордны бүжгийн шинжээр баяжин олон төрөл хэлбэртэй болсныг харуулж байна.

Мөн Юань улсын судар бичгийн 71-р дэвтэрт 27 орчим ордны бүжгийн талаар бичгээр тэмдэглэснээс үндэслэн доктор Б.Ринчен "Монголчуудын бүжиг наадам өгүүллэгт бүжгийн найруулагчид ард түмнийхээ эртний өндөр соёлын үлэмж өвийн зүйлээс санаа авч сайхан бүжиг боловсруулах сэдэв их бийг энэ нэгэн зүйлээр толилуулья" гэж тэмдэглээд эртний үеийн ордны бүжгийг дэлгэн гаргаж түүхэн судлалын шинжтэй үнэт хэрэглэгдэхүүн болсон нь тодорхой билээ. Монголын нууц товчоонд "Монголын жаргалан дэвсэн хуримлах жаргал бөлгөө" гэж гардаг нь XIII зууны үеийн монголчуудын нэн эртний ордны бүжиг тухайн үеийн монгол хаадын ордны бүжигт өргөмжлөгдөн дэвшиж төрийн тайлга еслолд хэрэглэгдэж байсныг гэрчилнэ.

Учир нь “суух нутагтай бол баян, уух устай бол буян”<sup>1</sup> гэдэгчлэн хөх толботой нүүдэлчин монголчуудын алтан ясны хэлтэрхий, алаг махны тасархай болсоны хувьд өөрийн өвөг дээдсийнхээ зан журмыг судлан ойлгох нь зүй есон бөлгөө.

Бидний судалгааны гол цөм гэвэл юуны урьд бүхий л монгол үндэстний шүтлэгийг тайлбарлахын зэрэгцээ тайллага тахилгын зан заншил хөгжим, бүжгийн хэлхээ холбоонд судлан харахыг хичээсэн болно. Энэхүү судалгааны ажлын хүрээнд Их Юань гүрний тайллага тахилгын хөгжмийн бүжгийн асуудлыг шинэлэг байдлаар судалгааны эх сурвалжид тулгуурлан судлан гаргав.

<sup>1</sup> Манарч харагдах эзэн хороо, Эзэн хороо хошууны газрын нэрсийн товч. Өвөрмонгол хэвлэлийн бүлэглэлийн Өвөрмонгол ардын хэвлэлийн хороо. С. Хасчулуун эмхтгэн найруулав. Хөх хот. 2011. Х.3.

Монгол бүжигт монгол хүний эрхэмсэг зан чанар, еслол хүндэтгэлийн намба төрх, гунхах, ганхах, туялзах хөдөлгөөн, морины явдлыг голлодог, сэтгэлийн хөдлөлийн тогтвортой байдал зонхилно. Монголчуудын бүтээсэн уламжлалт бүжгийн баялаг өв санг малчин түмний хөдөлмөрийн зан үйлийн бүжиг, хаадын ордны болон угсаатан ястны бүжгийн төрөл зүйлээс судлан мэдэж болно. Эдгээр төрөл зүйл нь олон зуун жилийн туршид өөрөө хөгжих тогтолцоонд шалгагдаж боловсорсон дахин давтагдашгүй манай ард түмний үнэт зүйлсийн тогтолцоонд тодорхой байр суурь эзэлсээр байх тийм өв уламжлал бөгөөд дэлхийн хэмжээнд ач холбогдлоо алдахгүй юм. Тэгэхээр Монгол үндэстний тайллага тахилгын хөгжмийн бүжгийн судалгааны асуудал нь энэхүү судалгааны хүрээнд илүү тодорхой харагдаж байна хэмээн дүгнэж болохоор байна.

#### ***4. Ордны тахилгын хөгжим бүжиг хийгээд тахилгын хөгжим бүжгийн асуудалд:***

Бүжиг урлагийг илэрхийлэх арга барил нь уран хөдөлгөөн юм. Энэхүү их уран хөдөлгөөн нь нэгэн төр гүрний ес заншил, дэг журмынх нь маш тодорхой нэгэн илэрхийлэл болж байдаг. Жишээлбэл: Энэтхэгээс дамжин орж ирсэн “Арван зургаан дагинын бүжиг” нь их өвөрмөц шинжтэй байсан. Төрийн их есноо тайллага тахилгын бүжиг гэж байдаг. Тахилгын бүжиг гэвэл уул ус, тэнгэр газар, дээдэстээ сүсэглэн мөргөн бүжиглэдэг бүжгийн төрлийг нэрлэх нэршил болно. Юань гүрний үеийн ордны тайллага тахилгын бүжигт тахилгын хөгжим бүжиг, дээдсийн сүмийн тахилгын бүжиг, “Арван гэрийн тахилгын хөгжим бүжиг” зэрэг тахилгын бүжиг байдаг.

Хубилай хаан Жүн Түнгийн 2-р онд өөрийн биеэр умард газрыг дайлахдаа зуны улиралын 4 сарын хөхөгчин гахай өдөр өөрийн биеэр хуучин Хуанжугийн баруун хойно тэнгэрт гүүний сүүгээр сацал өргөж, зөвхөн алтан ургийнхан оролцсон зан заншлаар еслол үйлджээ<sup>1</sup>. Эндээс харвал монгол хаад тахилга үйлддэг газрыг ихэд эрхэмлэж, зүг чигийг бэлгэдэлд анхаардаг байсныг дээрх судраас болно. Учир нь монголчууд өмнө зүгийг наран ургах зүг хэмээн эрхэмлэхийн зэрэгцээ баруун зүгийг зөв зүг хэмээн эрхэмлэхийн зэрэгцээ энэ цаг дор монгол хаад баруун зүгт хандаж сацал өргөж байсан нь өөрийн эх нутаг, газар шороо, өвөг дээдэстээ танилга үйлдэж байсныг илтгэж байсан болов уу хэмээн үзэж болохоор байна.

Энэхүү судалгаанд хамаарал бүхий хятад судрыг олон эрдэмтэд орчуулсан байдаг. Юан улсын түүхийг 30 жил судалсан эрдэмтэн Чулуунбагана тахилга — нийслэлийн ойр хавийн тахилга, хотын дүүрэг дэх тахилга, Монголын тахилга нь Хубилай хааны үеэс уламжилж ирсэн хэмээн өөрийн бүтээлдээ дурдсан байдаг. Тэнгэрийг тахих, газар, шорооны эздийг тахих зэргээр тахилгын олон хэлбэр байдаг хэдий ч тахилгыг ямар сар, улиралд тахих нь харилцан адилгүй хэмээн өгүүлжээ. Тахилга, газар шорооны тахилга, өвгөн сүмийн тахилга зэрэгт ордноо өлгөх хөгжмийг хэрэглэнэ. Хөгжимчид 361 хүн байна<sup>2</sup> хэмээсэн нь тахилга үйлдэх цаг хугацааг улирал бүрээр нарийн тогтоохын зэрэгцээ тахилга бүрт өлгөх хөгжим өөр өөрийн онцлогтой байсан зэргийг эндээс мэдэж болно.

---

<sup>1</sup> Юан улсын судар. Дандаа чянсан хэмээх Дэмчигдоржийн орчуулга. 72 дугаар дэвтэр. Улаанбаатар, 2016. Х. 85.

<sup>2</sup> Юань улсын судар, Бээжин хэвлэл. Еслол хөгжмийн 67. Х. 18.

Их Юань гүрний үеийн оны цолын дуудлага нь хүртэл Сүн улс, Ляо улс, Алтан улсынхтай ойролцоо юм. Их Юань гүрний үе бол соел урлагт Сүн улс, Ляо улс, Алтан улсын соел урлагийн нөлөө шингэсэн хэмээн үзэж болохоор байна.

Арабын жуулчин Ибн Баттута, Ханжуд, Сартуул орны дуу хөгжим нь хүмүүст ихээр таалагдаж байсан тухай тэмдэглэжээ.<sup>1</sup>

Түүхэн судар бичгээс үзвэл мандсан их Юань гүрний үе бол соел урлагийн мандал хөгжлийн илүү ихээр дэлгэрүүлэх таатай орчин байсан гэдэг нь дамжиггүй. Эртний нүүдэлчин Монголчууд өөрийн өвөрмөц аж ахуйн тогтолцоо, амьдралын шаардлагаас болж унасан шороо, өлгий нутаг дээрээ эл олон гайхамшигт соелыг бүтээсэн юм. Энэ нь тухайн үед өмнө зүгт Хятад орон, Европын олон улсад цөм нөлөөтэй болж байлаа. Тухайн үеийн Монголын өндөрлөг дээр амьдарч байсан нүүдэлчин угсаатан аж ахуй соел урлагийн талаар нэлээд хөгжилтэй байсан төдийгүй улмаар хүчирхэгжин олон улсыг эрхшээлдээ оруулсан байдаг<sup>2</sup>.

Нүүдэлчин Монголчуудын дайн тулаан, гадаад бодлого нь тэднийг улам хүчирхэгжүүлсэнээс гадна дэлхийн үндэстний соелын солилцоог түргэтгэн дэлхийн соелын хувьд шинэлэг шат, дэвшлийг авчирсан хэмээн үзэж болох талтай.

Түүхэн тэмдэглэлээс үзвэл: Хятадын Тан 唐, Ео 尧-гоос өмнөдөн нүүдэлчин угсаатныг хамтад нь ди 狄 хэмээн нэрлэж байсан бол “Шижи бичиг”, “Хүннүгийн түүх”-аас эхэлж, хятад сударт “Хүннү” хэмээн ерөнхийд нь тэмдэглэх болсон байна.

XII зуунаас XIII зууны үед монголчууд нэгэнт дуу хөгжим болон бүжгийн урлаг ихээхэн хөгжиж байсан ажээ. XIII зууны эхээр Монголын Найман аймагт хөгжим тааруулах хууртай болжээ. “Засагт туслах нэвтэрхий толийн үргэлжлэл”-д тэмдэглэснийг үзвэл: Тайан улсын үед “Хабулт их дуун Хойхри мангар чөтгөр барсын толгой, шишиб эрс Монгол эрс, шилдэг эрс, аялгуу, Сэнгэхумдаа, дархан Арсалчиу, Эрнээн, хар хошуу, Дүндамба, Зулам, Зүүр, Понсогүр, Балданхэвш, Ширээд, мах, шангүн, тогос, алтансүйх” зэрэг 20 хэдэн зүйлийн хөгжимтэй байжээ.

Эртний Монголчууд үхрийн арьсан том хэнгэрэг хийж, дайн байлдаанд хэрэглэдэг, дайн байлдаан эхлэхээс өмнө хэнгэрэг дэлдэн дуу дуулдаг заншилтай байжээ. Бас бөө нарын хэрэглэх еслолын бяцхан хэнгэрэг хэмээн нэрлэх нь бий.

Тухайн үед Монголын ноерхогчдын ордны хөгжим бүжиг нь ихээр хөгжжээ. Чингис хаан Тангуд иргэний хуучин хөгжмийг хэрэглэж, Өгөдэй хаан бас Алтан улсын орхигдуулсан тайчан хөгжмийг Дайдуд хэрэглэж байжээ. Хубилай хааны үед хаан ордонд дууч, бишгүүрч, царгич, шүлэгч зэрэг уран сайхны тусгай ажилчидтай байсан бөгөөд хөгжимчин гэж дөрөв таван зуун хүнтэй байв. Ван нар эрхэт түшмэд, цэрэг дайнд мордох бүр эмэгтэй хөгжимчидийг дагуулж явдаг байжээ. Ордоны хөгжим бүжиг олон төрөл зүйл

<sup>1</sup> Чиу Ши Шэн. Юан улсын түүхийн тойм. Өвөрмонголын Соелын хэвлэлийн хороо. Хайлаар хот. 1984. Х. 318.

<sup>2</sup> Монгол нүүдэл соелын түүхэн мөрдөл. Жагар найруулав. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хороо. Хайлаар хот. 2001. Х. 412.

нь бөгөөд хүчирхэг байв. Төрийн тайлга, ургац тарианы тайлга бүр нь тус тусын тусгай хөгжим бүжигтэй байжээ. Бүжгийн хэлбэр, урлагийн хэв маяг нь улам сайжирсан байна<sup>1</sup>.

**5. Юань гүрний ордны тахилгын хөгжим бүжгийг Сүн улс, Ляо улс, Алтан улсын тайлга тахилгын хөгжим бүжигтэй харьцуулан судалсан нь.**

Их Юань гүрэн, Сүн улс, Алтан улс нь соел урлагийн талаар их эртний холбоотой. Тан улсын үед ший жүжгийн хэв үлгэр нэгэнт буй болсон байна. Сүн улс, Алтан улсын үе болоход нэн олон, нэг алхам хөгжсөн байна. Сүн улсын үеийн хотод аль олон ардын уран сайханч нар театрт ярьж дуулах тоглолт гаргаж эхлэв. Сүн улс Алтан улсын үед нэгэн зүйлийн “Найрал аялгуулал” хэмээх жүжиг дэлгэрэн гарч байжээ. Энэ нь дуулж ярих боловч голдуу дуулахаар гол болгож, дуулах хэсэг нь эл ордны аясыг холбон хамтруулсан юм.

Судалгааны явцад ажиглахад дурдан буй гурван улсын хөгжим, бүжиг хөгжихөд томоохон нөлөө үзүүлсэн зүйл нь хөгжим, бүжгийн асуудлыг эрхэлсэн тухайлсан яамтай байсан явдал хэмээн үзэж болно. Тухайлбал, Юань улсын судрын далан нэгдүгээр дэвтэрт “Еслол хөгжмийн тэмдэглэл хорин хоёрдугаар, еслол хөгжим гуравдугаарт Юань гүрний Их хөгжмийн яам, Ихэд дайлагны эрхэлсэн яам, Еслол хөгжмийн яамны суралцсан түшмэл, эрхэлсэн түшмэл, дансалсан түшмэлийн ажлын чиг үүрэг, хөгжмийн түшмэл, хөгжим-бүжгийн багш, хөгжимчин, бүжигчин, удирдагч нарын гүйцэтгэх үүрэг, хувцас хэрэглэл ямар байх талаар нарийвчлан тогтоож өгдөг байсан нь харагдана.

Мөн еслол хөгжимд хэрэглэх аялгууг ямар онолоор хэрхэн найруулж, хэд давтах, хэрхэн хувилбарлах<sup>2</sup>, хэрхэн байрлуулах, тэдгээрийн дэг найруулгыг хэрхэн хийх талаар нарийн өгүүлж байсан төдийгүй тухайн цагт хөгжим, бүжиг өндөр хөгжлийг олох болсон тухайлсан яамны зохион байгуулалттай байсны эерэг тал хэмээн үзэж болохоор байна. Тухайлсан яамнаас эрхлэн бүжиг, хөгжмийн төрөл болон түүний хөгжлийн тухай асуудлыг судар зохиолд тэмдэглэх болсноор бидний үед уламжлагдан ирсэн нь судалгааны хувьд үнэ цэнэтэй билээ. Тухайлбал, хөгжмийн анги, еслол хөгжмийн анги, бүжиглэсэн бүжиг, үүсгэсэн аялгуу, тэрчлэн хөгжимчид, бүжигчид, дуучдын хувцас хэрэглэл, хөгжмийн зэмсэгүүдийг тэмдэглэсэн байдаг.

Эдгээрээс үзвэл Сүн улс, Ляо улс, Алтан улсын соел нь хоорондоо харилцан хамааралтай тул ижил тал ихтэй байсан хэмээн үзэж болохоор байна. Сүн улс, Ляо улс, Алтан улс, Их Юань гүрэн бол он цагийн хувьд их ойролцоо оршин тогтож, төр улсаа байгуулж байсан улсууд болно.

Түүнчлэн Ляо, Алтан, Юань улсын ойролцоо тал нь нүүдэлчин соел ахуйтай ард түмэн тул харьцангуй ижил, сэтгэлгээний хувьд ойр, зан чанар нь нутаг шигээ тэнүүн уужим, уул шигээ сүрлэг, омголон тулд энэ бүх онцлог нь тэдний хөгжим болоод бүжигт тусгалаа олсон байдаг.

---

<sup>1</sup>Монгол түүхийн лекц. Дамба эрхлэн найруулав. Өвөрмонголын Их сургуулийн Хэвлэлийн хороо. Хөх хот. 1998. Х. 319.

<sup>2</sup> С.Соронзонболд. Монгол хөгжим // Юань улсын ордны хөгжим, бүжиг, жүжиг, хувцас. Улаанбаатар, 2013. Х. 3.



Сүн улсын хөгжим бүжигт суурин аж ахуй, соел, ард түмний зан чанар, заншлын онцлог байдал тусгалаа олсон нь тэдний бүжиг, хөгжмийн илүү нарийн, сонгодог хэлбэртэй байдгаас бид харж болно.

Юань гүрний хөгжим бүжгийн ерөнхий шинж нь:

1. Эрхэмсэг дээдсийн оролцоотойгоор голлоно.
2. Удаалаг төв ихэмсэг хэв намбатай
3. Хөгжмийн зэмсэг төгс төгөлдөр, тоогоор маш арвин.

Үндэстний соелын өвөрмөц шинж, иргэншлийн хэв шинжээр хүн төрөлхтөний гайхамшгийг таньж болдог гэдгийг судлаачид бүтээлдээ тэмдэглэсэн төдийгүй энэ бүхэн нь тухайн ард түмний соел болон сэтгэлгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Аливаа нэгэн үндэстэн аль нэгэн улсын хөгжим болоод бүжгийн хөгжлийн түвшин нь тус гүрний ард түмний оюуны сангийн охийг илтгэдэг хэмээн үзэж болно.

**Дүгнэлт.** Энэхүү судалгааны ажлыг хийсний үндсэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

- Монголчууд эртнээс тайлга тахилгын шүтлэг бишрэлийг илэрхийлэхийн тулд хөгжмийн зэмсгээр сэтгэл уяраан далд сэтгэлийн шидийг бадраахын тулд ая хөг дор зохицуулан бүжгийн үйлийг удирддаг байв. Энэ бол тайлага тахилга хийгээд хөгжим бүжгийн чухал нэгэн холбоос байсан хэмээн үзэж болохоор байна.

- Монголын их еслолоор биелэгээ бүжиг бүжиглэсэн гэж Юань гүрний түүхийн орчуулга бичгийн гэрчлэлийн нөхвөрт тэмдэглэсэн байдаг байна. Эндээс үзвэл ардын бүжгийн эх үүсвэр эртнээс уламжлагдан дээдэс доодосгүй бүжин цэнгэцгээдэг байсан бөгөөд дуулалт бүжиг, хундаганы бүжиг гэх мэтээр олон төрлийн бүжгийг бүждэг байжээ. Энэ бүхэн нь монгол төрийн бүжиг ордны бүжгийн шинжээр баяжин олон төрөл хэлбэртэй болсныг харуулж байна. Иймээс Монгол үндэстний тайллага тахилгын хөгжмийн бүжгийн судалгааны асуудал нь энэхүү судалгааны хүрээнд илүү тодорхой харагдаж байна хэмээн дүгнэж болохоор байна.

- Монгол төрийн бүжиг нь хөгжлийн эхэн үедээ нүүдэлчдийн аж төрөх есонд зохицсон, бөө мөргөлийн зан үйл бөөлөх үйл хөдөлгөөнтэй холбоотой өвөрмөц онцлогтой байсныг тэмдэглэх хэрэгтэй. Ялангуяа Юан улсын хааны ордон Дайду хотноо шилжсэнтэй холбогдон монголын бүжгийн язгуур уламжлалыг олон үндэстний бүжгээр баяжуулсны дотор хятад болон бусад үндэстний бүжгийн нөлөө их байсан бололтой. Их Монголын Юань гүрний үед төрийн еслол хүндэтгэлийн бүжиг нь төгөлдөр шинжийг олсон бөгөөд дуу, хөгжим, бүжиг хавсарсан бүрэлдэхүүнээр хүндэтгэл еслолын бүжгүүдийг хийдэг байжээ.

- Судалгааны явцад ажиглахад дурдан буй Гурван улсын хөгжим, бүжгийн хөгжилд томоохон нөлөө үзүүлсэн зүйл нь хөгжим, бүжгийн асуудлыг эрхэлсэн тухайлсан яамтай байсан явдал хэмээн үзэж болно. Тухайлбал, Юань улсын судрын далан нэгдүгээр дэвтэрт “Еслол хөгжмийн тэмдэглэл хорин хоёрдугаар, еслол хөгжим, гуравдугаарт, Юань гүрний Их хөгжмийн яам, Ихэд дайлагны эрхэлсэн яам, Еслол хөгжмийн яамны суралцсан түшмэл, эрхэлсэн түшмэл, дансалсан түшмэлийн ажлын чиг үүрэг, хөгжмийн түшмэл, хөгжим-бүжгийн багш, хөгжимчин, бүжигчин, удирдагч нарын гүйцэтгэх үүрэг, хувцас хэрэглэл ямар байх талаар нарийвчлан тогтоож өгдөг байсан нь харагдана. Ийнхүү цаг

цагийн урсгалаар хөгжим, бүжгийн шинэ бүтээл, хувилбарууд бий болж хөгжсөөр байсан нь дамжиггүй.

• Их Юань гүрний үед Монголын хаад соелын талаар чөлөөтэй бодлого хэрэгжүүлж байсны улмаас их нийслэл Дайду хотод дэлхийн олон орны соел харилцан бие биедээ нөлөөлж, улам хөгжих таатай орчин бүрдэж байсан нь монголчуудын хөгжим бүжиг, урлаг улам төгөлдөржин хөгжих үндэс болжээ.

#### **Ашигласан материал**

1. Дулам С. Монгол домог зүйн дүр. Өвөрмонголын соелын хэвлэлийн хороо. Хайлаар, 1998. Х. 1.
2. С. Дулам. Дорно дахины уран зохиолын үүд. Улаанбаатар, 2004. Х.161.
3. Хэрлэн.Г. Монгол ардын хөгжмийн зэмсгийн түүхээс. Улаанбаатар, 2009. Х. 17.
4. Манарч харагдах эзэн хороо, Эзэн хороо хошууны газрын нэрсийн товч. Өвөрмонгол хэвлэлийн бүлэглэлийн Өвөрмонгол ардын хэвлэлийн хороо. С. Хасчулуун эмхтгэн найруулав. Хөх хот, 2011. Х. 3.
5. Юан улсын судар. Дандаа чянсан хэмээх Дэмчигдоржийн орчуулга. 72 дугаар дэвтэр. Улаанбаатар, 2016. Х. 85.
6. Юань улсын судар, Бээжин хэвлэл. Еслол хөгжмийн 67. Х. 18.
7. Чиу Ши Шэн. Юан улсын түүхийн тойм. Өвөрмонголын Соелын хэвлэлийн хороо. Хайлаар хот, 1984. Х. 318.
8. Монгол нүүдэл соелын түүхэн мөрдөл. Жагар найруулав. Өвөрмонголын сурган хүмүүжлийн хороо. Хайлаар хот, 2001. Х. 412.
9. Монгол түүхийн лекц. Дамба эрхлэн найруулав. Өвөрмонголын Их сургуулийн Хэвлэлийн хороо. Хөх хот, 1998. Х. 319.
10. С.Соронзонболд. Монгол хөгжим // Юань улсын ордны хөгжим, бүжиг, жүжиг, хувцас. Улаанбаатар, 2013. Х. 3.

Тус өгүүлэл 2023 оны 11-р сарын 23-ны өдөр редактор хүлээн авсан; 2023 оны 12-р сарын 7-ний өдөр хэлэлцээд баталсан; 2024 оны 2-р сарын 28-нд хэвлүүлэхээр хүлээн зөвшөөрсөн.

---

A STUDY ON THE RELATIONSHIP BETWEEN RELIGION AND PALACE MUSIC  
AND DANCE IN THE GREAT YUAN PERIOD

*Altangerel Erdenezurkh*

PhD student,

Mongolian National University of Education

Baga toiruu-14, Khoroo 8, Ulaanbaatar, Mongolia 14191

erdirh915@163.com

*Abstract.* The article studies the offering music and dance during the Yuan Dynasty. In addition to the comparative research on the interrelations between religion and believes of Mongolians and the sacrifice music and dances and hereby introduce some of the research work results. To conduct the research work, we studied regional offering and sacrifice ceremonies, feature and music and dances of Yuan Dynasty and touched the development issues, too. According to our points of view, research on the regional offering and sacrifice ceremonies, feature and music and dances of Yuan Dynasty shall be very important not only for the development of the music and dance development of Mongolia, but also for the research of the sacrifice and offering ceremonies of Mongolians. In accordance with the history of Mongolia, Palace music and dances have developed during the Yuan Dynasty, therefore the article has reflected the major factors influencing on this development rate. The article reflects research works on political and religious meaning of the shamanism in the beginning of the Mongolian state and government and mentioned the outstanding ceremony of sky offering and sacrifice ceremonies on basis of the historical evidences and facts. We may consider that dance movements were included into the shamanist ceremonies conducted during the sky sacrifice ceremonies as different art types have not been separated but were conducted as a complex ceremony at this time; therefore, the believes of people were also complex worshipping lyrics and music, actions and performances, images and roles of these ceremonies.

*Keywords:* The Yuan dynasty, statecraft, military strategy, tribute, state policy, Mongolian steppe

*For citation*

Altangerel Erdenezurkh. A study on the relationship between religion and palace music and dance in the Great Yuan period. *Oriental Vector: History, Society, State.* 2024; 1: 66-76 (In Mong.).

*The article was submitted 23.11.2023; approved after review 07.12.2023; accepted for publication 28.02.2024.*